

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН
2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт				Хувь
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар /	
1.1.	“Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах	-	Журмын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	4	Журмын 4.1 дэх заалтын хүрээнд аймгийн Засаг дарга БНСУ, Япон Улсад албан хэргээр зорчиход удирдамжийн төсөл боловсруулан Гадаад харилцааны яамнаас санал авсан. 3.3 дахь заалтын хүрээнд гадаад арга хэмжээний төлөвлөгөөг ГХЯ-нд хүргүүлсэн. 4.3 дахь заалтын хүрээнд аймгийн Засаг дарга, Япон Улсын Эхиме мужийн Сэйёо хотын дарга хоорондын цахим уулзалтад Гадаад харилцааны яамнаас ярианы сэдэвтээ санал авсан. Мөн БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консул Ли Яньжюнь болон бусад төлөөлөгчдийн уулзалт болон цахим форумд оролцох удирдамжийг ЗГХЭГ, Гадаад харилцааны яаманд хүргүүлэн чиглэл зөвлөмж авч уулзалтын илтгэх хуудсыг хүргүүлсэн. 4.6 дахь заалтын хүрээнд сумд, агентлагуудад журмын хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлсэн. 5.5 дахь заалтын дагуу гадаад арга хэмжээний тайланг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 6 арга хэмжээ зохион байгуулав.	100
1.2.	Арга хэмжээ: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 75 дугаар зүйлийг дагаж мөрдөх	-	Зөвшөөрөл авч байгуулсан гэрээний тоо	1	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Япон улсаас Монгол улсад суугаа Элчин Сайдын Яам хоорондын "Дундговь аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн засварын төсөл"-ийг Гадаад харилцааны яаманд хянуулан зөвшөөрөл авч байгуулсан.	100

1.3	Гадаадын албаны болон аж ахуй нэгж, байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөлтэй уулзахдаа Монгол Улсын гадаад бодлогын байр суурийн хүрээнд ярилцах, ярианы сэдэвтээ Гадаад харилцааны яамнаас санал авч байх	-	Гадаад харилцааны яамнаас санал авсан уулзалтын тоо	1	Дундговь аймаг, Япон Улсын Эхиме мужийн Сейёо хот хоорондын цахим уулзалтын албан бичгийг Гадаад харилцааны яаманд хүргүүлэн ярианы сэдэвтээ санал авсан.	100
1.4	Гадаадад айлчлах, албан хэргээр зорчих, олон улсын арга хэмжээнд оролцох, албан ёсны яриа хэлэлцээ явуулахдаа удирдамжийн төсөл боловсруулж, Гадаад харилцааны яаманд хүргүүлж санал авч байх	-	Удирдамжийн төсөл боловсруулан санал авсан гадаад айлчлалын тоо	1	Аймгийн Засаг дарга БНСУ, Япон Улсад албан хэргээр зорчиход удирдамжийн төсөл боловсруулан Гадаад харилцааны яамнаас санал авсан.	100
1.5	Хувийн хэргээр гадаадад зорчихдоо албан ёсны уулзалт, яриа хэлэлцээ хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, ёслолын арга хэмжээнд оролцохгүй байх	-	Гадаадад айлчилсан тухай илтгэх хуудас ирүүлсэн эсэх	Тийм	Аймгийн Засаг дарга БНЭУ-д хувийн хэргээр зорчихдоо ЗГХЭГ-аас зөвшөөрөл авсан.	100
1.6	Гадаадад айлчилсан, албан хэргээр зорчсон, олон улсын арга хэмжээнд оролцсон, албан ёсны яриа хэлэлцээ явуулсан тухай илтгэх хуудасны хувийг ажлын 7 хоногийн дотор Гадаад харилцааны яаманд хүргүүлж байх	-	Гадаадад айлчилсан тухай илтгэх хуудас ирүүлсэн эсэх	Тийм	Аймгийн Засаг дарга БНСУ, Япон Улсад албан хэргээр зорчсон илтгэх хуудасны хувийг ЗГХЭГ, Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.	100
1.7	Гадаад хамтын ажиллагааны 2021 оны тайланг гадаад арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн хамт 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор, 2022 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг 3 дугаар сарын 1-ний дотор Гадаад харилцааны яаманд хүргүүлэх	-	Хугацаандаа тайлан, төлөвлөгөөг хүргүүлсэн эсэх	Тийм	Гадаад хамтын ажиллагааны 2021 оны тайланг 2022 оны 01 дүгээр сарын 28-нд, 2022 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 28-нд Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.	100
1.8	“Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-д заасны дагуу зөвхөн эзэмших эрхтэй албан тушаалтанд албан паспорт мэдүүлэх	-	Журмын дагуу албан паспорт мэдүүлсэн албан хаагчдын тоо	2	Журмын хүрээнд дипломат болон албан паспорт эзэмших эрхтэй 11 албан тушаалтанд паспорт мэдүүлсэн.	100

1.9	“Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг чанд мөрдөх, хяналт тавих, тайлан, мэдээллийг тогтоосон хугацаанд Гадаад харилцааны яаманд хүргүүлэх	-	Дипломат, албан паспорт эзэмшигчдийн тайланг хугацаандаа хүргүүлсэн эсэх	Тийм	Дипломат, албан паспорт эзэмшигч албан тушаалтнуудын тайланг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.	100
1.10	Орон нутгийн түүх, соёлын дурсгалт газрууд, байгалийн сэдвээр тусгай танилцуулга, сэтгүүл, ном, боть, контент, CD, DVD зэргийг гадаад хэлээр боловсруулахад Гадаад харилцааны яамтай хамтран ажиллах	-	Гадаад харилцааны яамтай хамтран контент боловсруул-сан эсэх	Тийм	Орон нутгийн түүх, соёлын дурсгалт газрууд, байгалийн сэдвээр тусгай танилцуулга, сэтгүүл, ном, боть, контент, CD, DVD зэргийг боловсруулаагүй болно.	0
Хэрэгжилтийн хувь						90

БАТАЛГААЖУУЛСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ТҮВШИНЖАРГАЛ

НЭГТГЭСЭН:
ГАДААД ХАРИЛЦААНЫ АЖИЛТАН

Б.АДЪЯА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э. ОДОНЧИМЭГ

